



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/510

Булган

┌ Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг ┐  
тэмдэгжүүлэх тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Булган аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 2.5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нутаг дэвсгэр дэх улсын хамгаалалттай үл хөдлөх дурсгалт газруудыг тэмдэгжүүлэх ажлыг 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулахыг аймгийн Музей /Ч.Баттунгалаг/-д үүрэг болгосугай.

2. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг тэмдэгжүүлэх ажлын зардлыг хавсралтаар баталж, шаардагдах 6 140 160 /зургаан сая нэг зуун дөчин мянга нэг зуун жар/ төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /А.Гантөмөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

